



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 9123

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 35.000.000 (гучин таван сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар Алтай сумын Бадрал багт худаг гаргах ажлыг гүйцэтгүүлэх эрхийг Алтай сумын Засаг дарга (Д.Эрдэнэжаргал)-д шилжүүлсүгэй.

2. Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон бусад шаардлагатай мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Алтай сумын Засаг дарга (Д.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

